



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2015. 02. 24 № 1/5

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА
Б.БАТСАЙХАН ТАНАА

Зөрчил арилгах тухай

Төсвийн тухай хуулийн 8.9.1 Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төрийн тусгай хамгаалалтын газрын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Засгийн газрын 2013 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж” төслийн хүрээнд хэрэгжих “Цэцэг” төвийн уулзварыг шинэчлэх ажлын явцад Төрийн тусгай хамгаалалтын газрын зарим барилга байгууламжийг буулгаж, нөхөн төлбөрийг барагдуулах гэрээг тус газрын дарга, “Гудамж” төслийн нэгжийн захирагч нар байгуулжээ.

Энэ гэрээний дагуу Төрийн өмчийн хорооны зөвшөөрөл шийдвэрээр зарим барилга байгууламжийг буулгасан боловч уг төслөөс Их тэнгэр цогцолборын хашаанд шинээр барьж өгсөн 300 м² талбай бүхий барилга, 71 м² талбай бүхий 4 автомашины гражийн барилгыг хүлээн авч, ашиглаж байгаа боловч өртөг зардал тодорхойгүй, зөвшөөрөл шийдвэр гараагүй гэх шалтгаанаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгаагүй байна. Мөн Их тэнгэр цогцолборын хашааны үүдэнд 2 ширхэг морьтой хүний хөшөөг хэн, ямар зорилгоор байрлуулсан ямар үнэ өртөгтэй, бүртгэл тайланд тусгах эсэх нь тодорхойгүй байна.


Энэ нь Их тэнгэр цогцолборын нягтлан бодогч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам” 3.1.1 дэх заалтыг үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлж байна. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй дээрх хөрөнгийг бүртгэл, тайланд тусгах нөхцлийг холбогдох байгууллагад тавьж, шийдвэрлүүлэх
2. Дээрх шийдвэрийг үндэслэн бүртгэл, тайланд тусгаагүй хөрөнгийг санхүүгийн тайлан тэнцэлд тусгах

Албан шаардлагын биелэлтийг 2015 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, хурандаа Б.Батсайхан, Их тэнгэр цогцолборын дарга Ц.Оргодол нарт хариуцуулав.

АХЛАХ АУДИТОР



Ж.БАТСАЙХАН